



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН  
ХОРОО

# **“Ардчилсан засаглал судалгаа”-ны 2011, 2012 оны үр дүн**

УЛААНБААТАР 2012

# Агуулга

---

Гарчиг

БҮЛЭГ I. УДИРТГАЛ	2
1.1 Ардчилал, ардчилсан засаглалын тухай нийтлэг ойлголт	2
1.2 Ардчилсан засаглал судалгааг явуулах шаардлага, үндэслэл	2
1.3 Судалгааны зорилго, ач холбогдол	3
1.4 Судалгааны арга зүй	3
БҮЛЭГ II. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН	5
2.1 Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөлөл (МХЗ-ын 60-р шалгуур үзүүлэлт)	5
2.2 Төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн төсөөлөл (МХЗ-ын 62-р шалгуур үзүүлэлт)	6
2.3 Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаарх иргэдийн төсөөлөл (МХЗ-ын 67-р шалгуур үзүүлэлт)	9
БҮЛЭГ III. ДҮГНЭЛТ	11

## БҮЛЭГ I. УДИРТГАЛ

### 1.1 Ардчилал, ардчилсан засаглалын тухай нийтлэг ойлголт

Ардчилал гэж Demos-ард, kratos-засаг гэсэн хоёр үгийн нийлбэрээс бүтсэн demokratia гэсэн грек үгээр түгээмэл нэрлэгддэг үйл явц юм. Ардчилал гэж чухам юу вэ гэдгийг олон янзаар тодорхойлдог бөгөөд *ардчилал нь цөөнхийг хамгаалсан олонхийн засаглал бөгөөд засаг төрийн байгууллыг сонгуулиар бүрдүүлэх, иргэдийн тэгш эрх, улс төрийн эрх чөлөөг хамгаалах, үндсэн хуулийн ёсыг дээдлэх явдал* юм.

Түүнчлэн орчин үед үндсэн хууль болон бусад хуулийг дээдлэх, ард түмний засгийг тогтоох, улс төрийн олон ургалч үзлийг зөвшөөрөх, иргэдийн эрх, эрх чөлөөг хангах, хүний эрхийн салгаж болохгүй үндсэн зарчмыг удирдлага болгосон нийгмийн байгууллыг ардчилсан засаглал гэж ойлгодог.

Ардчилал, ардчилсан засаглал нь өөрөө үйл явц учраас түүнийг ямар нэг байдлаар хэмжих асуудал зайлшгүй гарч ирнэ. Ардчилсан засаглал хэрхэн хөгжиж, бэхжиж байгааг хэмжих нь нийгмийн эсвэл эдийн засгийн үзэгдлийн нэгэн адил тоон үзүүлэлтээр шууд илэрхийлэгдэж, хэмжигддэггүй хэцүү асуудал боловч олон улсын байгууллага, судлаачид, эрдэмтэд ардчиллыг хэмжиж болох тоон үзүүлэлтүүдийн талаар олон саналыг дэвшүүлээд байгаа юм. Олон арван судлаачид өөрсдийн үзүүлэлт, загварыг боловсруулан гаргаж ирсний дотроос Дахлын<sup>1</sup> Полиархи хэмжүүр, төрийн бүтцийн үнэлгээ, Ванханены ардчиллын индекс, Марк Газиоровскийн улс төрийн дэглэмийн ангилал, Монти Г.Маршалл, Кейт Жаггерс, Тед Гурр нарын төрийн байгууллын мэдээлэл зэрэг ойлголт, аргачлалын ялгаа бүхий тэргүүлэх хэмжүүрүүдийг ардчиллын үндсэн хэмжүүрүүд гэж үздэг.

Олон улсын байгууллагаас санал болгож буй үзүүлэлтүүд нь ерөнхийдөө хоёр хэсгээс бүрдэж байна. **Нэгд**, үндсэн үзүүлэлтүүд, тухайлбал, парламентын хөгжил, сонгуулийн систем ба үйл явц, шүүх засаглал ба хүний эрх, и-засаглал ба мэдээллийн хүртээмжтэй байдал, төвлөрлийг сааруулах, орон нутгийн засаглал ба хот, хөдөөгийн хөгжил, төрийн удирдлагын шинэчлэл, авилгалын эсрэг тэмцэл, **Хоёрт**, тухайн улс орны онцлогийг тусгасан нэмэлт үзүүлэлтүүд байна.

Ардчилсан засаглалын нэмэлт үзүүлэлтүүдээр, жишээ нь ардчилсан засаглалыг хэмжихийг соёл иргэншил, геополитикийн байдал болон эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн агуулгаар нь зорьж байна. Дээр дурдсан үзүүлэлтүүд нь одоогоор олон улсын хэвлэл, мэдээллийн хэрэгсэл мөн засаглалын үзүүлэлтүүдийг тооцох, шууд дүгнэлт гаргахад ашиглах боломжгүй ч улс орнуудыг хээл, хахуулийн эсрэг эрх зүйн актуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ашиглагдаж байна.

### 1.2 Ардчилсан засаглал судалгааг явуулах шаардлага, үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 13-р тогтоолд “...Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хянах үзүүлэлт, арга зүйг боловсронгуй болгох, хэрэгжилтийг үзүүлэлт бүрээр дүгнэх, хяналт тавих, төрөлжсөн болон тусгайлсан мэдээллийн санг улсын хэмжээнд, аймаг, нийслэлийн түвшинд холбогдох мэдээллээр бүрдүүлж ажиллахыг Засгийн газар /С. Баяр/, Үндэсний статистикийн хороо /П. Бямбацэрэн/, Авлигатай тэмцэх газар /Ч. Сангарагчаа/, Төрийн албаны зөвлөл /Ж. Норовсамбуу/, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс /Д. Солонго/-т тус тус үүрэг болгосугай” гэж заасан.

Мөн “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7-р зүйлийн 5 дах хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсгийн “а”-д зааснаас бусад хэсэгт заасан тооллого явуулах хугацааны товыг Засгийн газар, түүвэр болон иж бүрэн судалгааныхыг Үндэсний статистикийн хороо тогтооно” гэж заасныг үндэслэн ҮСХ-ноос Мянганы хөгжлийн “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” 9-р зорилгын 22-р зорилт “Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэн сахиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломжийг олгох”, 23-р зорилт “Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх”, 24-р зорилт “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” зорилтуудын хэрэгжилтийг улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаархи иргэдийн төсөөлөл, төрийн байгууллагын үйл ажиллагааны болон төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаархи иргэдийн төсөөлөл ямар байгаа талаарх мэдээлэл цуглуулснаар дээрх зорилтуудын хэрэгжилтийг хянах боломж бүрдэнэ. Иймд холбогдох мэдээллийг ҮСХ-ноос тогтмол зохион байгуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” (ӨНЭЗС)-ны хавсралт /модул/ судалгаагаар цуглуулахаар тогтож, ҮСХ-ны даргын 2008 оны 07 сарын 23-ны өдрийн 10/100 тоот тушаалаар судалгааны үзэл баримтлалыг баталсан болно.

### **1.3 Судалгааны зорилго, ач холбогдол**

“Ардчилсан засаглал” судалгааны зорилго нь Монгол Улсын Мянганы хөгжлийн 9 дүгээр зорилгын хэрэгжилтийг хянах, дээр дурьдсан гурван шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг цуглуулах явдал бөгөөд ӨНЭЗС-ны дэд түүвэрлэлтэд хамрагдсан нийт өрхийн гуравны нэг буюу 3744 өрхийн насанд хүрсэн нэг гишүүн (3744 иргэн)-ийг хамруулан судалгааг улирал бүр явуулах нь уг шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд, байнгын давтамжтай тооцох боломжийг олгож байгаад судалгааны ач холбогдол оршино.

### **1.4 Судалгааны арга зүй**

Энэхүү хавсарга судалгааны судлагдах нэгж нь ҮСХ-ноос сар бүр тогтмол явуулдаг Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд хамрагдаж байгаа өрхүүдийн 18 ба түүнээс дээш насны гишүүд байна.

Судалгааны түүвэрлэлт нь ӨНЭЗС-ны түүвэрлэлт дээр үндэслэн хийгдсэн дэд түүвэрлэлт бөгөөд түүврийн хэмжээ нь ӨНЭЗС-нд нийт хамрагдсан өрхүүдийн гуравны нэг буюу улиралд 936 өрх, жилдээ 3744 өрхийн насанд хүрсэн нэг гишүүн, өөрөөр хэлбэл улиралд 936, жилдээ 3744 хүн байна.

Судалгаанд хамрагдах хүн амыг сонгохдоо ӨНЭЗС-нд хамрагдсан өрхийн гишүүдийн жагсаалтаас / ӨНЭЗС-3 маягтын 1-р бүлэг буюу өрхийн ам бүлийн жагсаалт/ санамсаргүй тооны хүснэгт ашиглан тоологч сонгоно.

## БҮЛЭГ II. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

“Ардчилсан засаглал” судалгааг 2008 оны III улирлаас эхлэн явуулж байна. Ингэснээр, МХЗ-ын 60, 62, 67-р шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд байнгын давтамжтайгаар тооцох боломжтой болсон.

### 2.1 Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөлөл (МХЗ-ын 60-р шалгуур үзүүлэлт)

Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө нь хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төр, санхүү, эдийн засгийн хувьд хараат бус байдал хангагдсан эсэхээр илэрхийлэгдэнэ. Мянганы хөгжлийн Хүний эрх, ардчилсан засаглалыг бэхжүүлэх төслөөс Монгол улсад анх удаа 2006 онд хийсэн Засаглалын төлөв байдлын судалгаагаар хэвлэл, мэдээллийн байгууллагуудын хараат байдал нь сэтгүүлчдийг хавчин мөшгих, барьж шийтгэсэн тохиолдлоос илүү түгээмэл, далд шинжтэй байна гэсэн дүн гарсан.

2012 оны “Ардчилсан засаглал” судалгааны дүнгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөллийг авч үзвэл, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь улс төрөөс хараат бус байдаг гэдэгтэй судалгаанд хамрагдсан иргэдийн 47.8 хувь нь санал нийлдэггүй, 20.7 хувь нь дунд зэрэг, 12.6 хувь нь санал нийлдэг гэж хариулсан байна. Мөн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, санхүүгээс нилээд хараат байна гэж иргэдийн дийлэнхи үзэж байгаа нь нийт авбал зохих онооны дөнгөж дөрөвний нэгийг авч байгаагаар илэрхийлэгдэж байна /Хүснэгт 2.1/.

### Хүснэгт 2.1

#### Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөлөл

	Хариулт, хувь												Үнэлгээний үзүүлэлт	
	Огт нийлдэггүй		Нийлдэггүй		Дунд зэрэг		Нийлдэг		Бүрэн нийлдэг		Мэдэхгүй			
	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл улс төрөөс хараат бус байдаг	9.4	13.9	32.3	33.9	24.5	20.7	11.9	11.6	1.1	1.0	20.9	18.8	24	21
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, санхүүгээс хараат бус байдаг	7.2	12.3	31.0	31.3	25.5	21.2	9.9	10.3	0.9	1.0	25.5	23.9	22	21
Монголчууд санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг	4.6	6.3	17.5	18.5	33.0	30.4	33.9	33.2	5.0	4.3	6.0	7.5	64	60

Судалгаанд хамрагдсан иргэдийн 23.9 хувь нь хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, санхүүгээс хараат бус байгаа эсэхийг “мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн нь өнгөрсөн оноос 1.6 пунктээр буурсан байна. Өөрөөр хэлбэл иргэд дээрх асуултын хувьд эргэлзээтэй, дундаж төсөөлөлтэй байгаа юм. “Монголчууд санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг” гэсэн хариултад судалгаанд хамрагдагсад 60 оноо өгсөн байна.

Иргэд олон нийтийн мэдээллийн байгууллагаас Монголын үндэсний телевизэд 94.4, үндэсний радиод 91, орон нутгийн телевизэд 85, хувийн телевизэд 82, FM радиод 78, өдөр тутмын хэвлэлд 70 гэсэн үнэлгээ өгсөн нь өнгөрсөн оноос 0.6-1.6 оноогоор буурсан байна. Харин шар хэвлэлийн хувьд 36.7 оноо өгсөн нь иргэд шар хэвлэлд бараг итгэдэггүй болох нь харагдаж байгаа бөгөөд өмнөх оныхтой харьцуулахад шар хэвлэлд итгэх итгэл 3.4 оноогоор нэмэгдсэн хандлага ажиглагдаж байна. /Хүснэгт 2.2/.

**Хүснэгт 2.2**

**Хэвлэл, мэдээллийн байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа иргэдийн хувь**

Байгууллага	Хариулт, хувь												Үнэлгээний үзүүлэлт	
	Огт итгэдэггүй		Итгэдэггүй		Дунд зэрэг		Итгэдэг		Бүрэн итгэдэг		Мэдэхгүй			
	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012
Үндэсний радио	0.7	1.3	4.7	4.8	21.3	20.5	50.2	50.0	9.9	10.5	13.2	13.0	91.7	91.0
FM радио /богино долгионы/	1.5	2.5	7.9	7.9	28.4	26.7	31.3	30.8	4.0	5.4	26.9	26.8	78.9	77.7
Монголын үндэсний олон нийтийн телевиз	0.8	0.8	3.1	3.6	18.9	19.1	56.5	56.6	17.8	16.6	3.0	3.4	95.0	94.4
Хувийн телевиз	1.3	1.9	8.2	8.4	32.1	32.1	43.7	41.1	5.9	6.9	8.9	9.6	83.9	82.3
Орон нутгийн телевиз	0.8	1.3	5.5	5.6	23.4	24.1	34.6	33.4	5.0	6.4	30.7	29.2	86.3	85.3
Өдөр тутмын хэвлэл	1.8	2.0	11.4	12.2	33.3	31.7	30.9	29.3	3.0	4.5	19.6	20.3	71.9	70.3
Шар хэвлэл	7.0	7.2	23.4	23.8	30.2	26.3	13.5	15.1	1.7	2.9	24.1	24.6	33.3	36.7

2012 оны жилийн эцсийн судалгааны дүнгээр хэвлэл, мэдээллийн байгууллагуудад иргэд 86 оноо өгсөн байгаа нь өмнөх оныхоос 1 оноогоор буурсан байна /Хүснэгт 2.3/.

**Хүснэгт 2.3**

**Хэвлэл, мэдээллийн байгууллагуудын талаарх үнэлгээ**

Байгууллага	Хариулт, хувь												Үнэлгээний үзүүлэлт	
	Маш муу		Тааруу		Дунд зэрэг		Сайн		Маш сайн		Мэдэхгүй			
	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл	1.2	2.2	7.9	7.5	24.1	24.3	50.4	49.8	9.2	9.7	7.2	6.7	87	86

**2.2 Төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн төсөөлөл (МХЗ-ын 62-р шалгуур үзүүлэлт)**

Төрийн захиргааны дээд байгууллагууд, түүний дотор хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны талаарх олон нийтийн төсөөлөл нь хүн амын дунд засаг, төрийн байгууллагуудад итгэл хүлээлгэж (үл хүлээлгэж) буй иргэдийн эзлэх хувь, түүнчлэн хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээг илэрхийлсэн үзүүлэлт юм.

2012 оны “Ардчилсан засаглал” судалгааны дүнгээр төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн төсөөллийг авч үзвэл:

Судалгаанд хамрагдсан иргэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, улсын сургууль, хувийн эмнэлэг, нийгмийн даатгал, халамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд сэтгэл ханамж хамгийн өндөр /86-91 оноо/ байгаа нь өмнөх оныхоос мөн үеийнхтэй ижил хандлагатай байна. Ерөнхийлөгчид өгсөн оноо өнгөрсөн оноос 10.9, УИХ 1.4, Засгийн газар 6.2 оноогоор тус тус буурч, харин улс төрийн намуудад итгэх итгэл 1.5 оноогоор нэмэгдсэн байна. /Хүснэгт 2.4/.

**Хүснэгт 2.4**


**Төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн төсөөлөл**

	Хариулт, хувь												Үнэлгээний үзүүлэлт	
	Маш муу		Тааруу		Дунд зэрэг		Сайн		Маш сайн		Мэдэхгүй			
	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012
Ерөнхийлөгч	4.0	7.3	13.8	16.5	41.7	40.3	31.1	25.4	3.4	3.9	6.1	6.6	66.0	55.1
УИХ	7.2	8.7	23.9	23.7	44.5	42.0	18.1	17.2	0.9	1.5	5.5	6.9	38.0	36.6
Засгийн газар	5.3	7.3	18.5	20.1	44.4	42.3	23.8	20.3	1.2	2.0	6.7	8.0	51.1	45.0
Улс төрийн намууд	7.8	9.8	29.3	27.5	37.6	36.9	12.0	12.8	0.6	0.9	12.6	12.1	25.4	27.0
Иргэний нийгмийн байгууллагууд /төрийн бус байгууллага/	2.3	3.6	15.5	15.0	36.8	32.9	26.5	27.3	1.7	2.6	17.2	18.5	61.3	61.7
Нийслэл/ аймгийн ИТХ	3.6	4.1	12.2	13.5	34.3	29.9	21.8	20.8	1.0	2.1	27.1	29.6	59.1	56.6
Дүүрэг/сумын ИТХ	3.7	5.2	15.0	15.5	36.0	31.3	24.2	21.3	1.3	2.0	19.8	24.7	57.8	52.9
Хороо/ багийн Иргэдийн Нийтийн Хурал	4.8	6.0	15.2	15.6	32.5	29.8	28.8	24.4	2.3	3.6	16.5	20.5	60.9	56.4
Нийслэл/ аймгийн Засаг дарга	2.6	3.8	11.4	12.6	32.9	28.8	32.1	28.6	3.4	4.9	17.6	21.4	71.7	67.1
Дүүрэг/ сумын Засаг дарга	3.4	4.7	13.6	14.9	34.7	33.0	33.2	27.4	2.7	4.5	12.4	15.5	67.9	62.0
Хороо/ багийн Засаг дарга	4.0	5.0	11.9	14.5	31.3	28.9	40.5	35.9	4.3	6.4	8.0	9.4	73.7	68.4
Дээд шүүх	3.1	4.5	10.1	11.8	22.5	22.8	13.3	12.9	1.8	2.5	49.2	45.5	53.3	48.5
Нийслэл/ аймгийн шүүх	2.8	3.7	10.5	11.4	24.1	23.6	14.0	13.8	1.3	2.0	47.3	45.5	53.7	51.0
Дүүрэг/сум дундын шүүх	2.8	3.7	9.9	11.3	24.4	23.0	14.0	13.8	1.3	2.2	47.6	46.1	54.8	51.5
Шүүхийн шийдвэр биелүүлэх газар	2.9	3.3	9.0	10.0	23.8	22.0	16.1	15.7	1.6	2.9	46.7	46.1	59.8	58.2
Замын цагдаа	2.4	2.9	10.2	9.1	27.5	27.6	38.7	37.8	4.7	6.0	16.6	16.7	77.5	78.5
Эрүүгийн цагдаа	2.7	3.4	10.2	10.8	30.2	28.8	30.4	29.9	3.8	4.7	22.7	22.4	72.5	70.9
Хэв журмын цагдаа	3.1	3.4	10.5	11.3	28.8	27.6	34.9	34.9	4.6	5.0	18.3	17.7	74.4	73.1
Авилгатай тэмцэх газар	10.6	9.4	17.3	15.8	22.9	22.3	8.7	15.2	1.5	3.6	39.1	33.7	26.6	42.7
Мэргэжлийн хяналтын газар	5.7	7.8	14.4	14.2	26.8	25.5	22.2	20.9	1.5	3.0	29.4	28.7	54.1	52.1
Аудитын газар	2.9	3.3	8.2	8.9	22.9	20.3	16.8	18.5	1.7	2.8	47.5	46.3	62.6	63.6
Гаалийн байгууллагууд	3.8	4.1	9.0	9.1	22.6	21.3	17.7	20.1	1.6	2.5	45.4	42.9	60.0	63.0
Газрын албад	6.7	9.3	15.1	17.0	28.9	24.8	21.2	21.8	1.5	1.8	26.7	25.2	51.1	47.2
Татварын байгууллагууд	1.7	2.4	6.8	7.2	23.0	24.0	40.3	36.2	3.3	3.9	25.0	26.3	83.8	80.7
Нийгмийн даатгалын байгууллагууд	1.4	1.4	4.0	4.8	23.0	19.9	53.3	52.0	6.5	8.2	11.8	13.7	91.8	90.7
Нийгмийн халамжийн байгууллагууд	1.2	1.3	4.3	4.6	21.6	20.7	55.3	52.2	8.9	9.6	8.8	11.7	92.1	91.2
Улсын сургууль	1.5	1.3	4.8	6.9	24.6	24.5	53.0	48.5	6.7	8.8	9.4	10.0	90.5	87.5
Хувийн сургууль	1.4	2.1	7.4	7.2	25.7	22.7	35.4	34.2	4.9	7.4	25.2	26.4	82.1	81.7
Улсын эмнэлэг	3.7	5.1	11.9	13.2	31.6	28.1	42.2	39.9	5.1	7.4	5.5	6.4	75.1	72.1
Хувийн эмнэлэг	1.3	1.4	5.1	5.8	22.1	20.1	46.7	43.4	6.3	9.8	18.5	19.6	89.3	88.0
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл	1.2	2.2	7.9	7.5	24.1	24.3	50.4	49.8	9.2	9.7	7.2	6.7	86.7	86.0

Иргэдийн үзэж байгаагаар Төрийн эрх мэдлийн дээд байгууллага, Шүүхийн байгууллага, ИТХ өөрийн үүргээ хангалтгүй биелүүлж байна. Төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаар иргэдийн өгч байгаа үнэлгээг байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлээр бүлэглэн дараах графикт харуулав.

Зураг 2.1

Үнэлгээний үзүүлэлт, оноо



2012 оны судалгаанд оролцсон иргэдийн өгсөн үнэлгээнээс харвал Нийгмийн даатгал, халамжийн байгууллагууд, сургууль эмнэлэг, цагдаагийн байгууллагуудад хамгийн өндөр буюу 74-91 оноо өгсөн нь бол ИТХ, шүүхийн байгууллага, төрийн эрх мэдлийн дээд байгууллагуудад хамгийн бага буюу 46-55 оноо өгсөн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад ардчилалын байгууллага 27, агентлагууд 2 оноогоор нэмэгдсэн бол бусад байгууллагын хувьд үнэлгээний оноо буурсан дүн гарчээ /Зураг 2.1/.

Хүснэгт 2.5

Төр, захиргааны байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа хүн амын эзлэх хувь

Байгууллага	Хариулт, хувь												Үнэлгээний үзүүлэлт	
	Огт итгэдэггүй		Итгэдэггүй		Дунд зэрэг		Итгэдэг		Бүрэн итгэдэг		Мэдэхгүй			
	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012
УИХ	6.5	7.9	24.2	23.8	42.5	40.5	20.9	20.0	1.2	1.6	4.7	6.2	41.8	40.6
Засгийн газар	4.6	6.3	20.4	22.3	41.9	40.5	26.0	22.3	1.4	2.0	5.7	6.6	52.3	45.9
Ерөнхийлөгч	4.8	7.2	16.6	21.3	38.7	36.6	30.8	25.8	3.7	3.2	5.6	5.8	61.8	50.4

Иргэдээс ерөнхийлөгч болон Засгийн газарт хүлээлгэж байгаа итгэл 46-50 оноотой байгаа нь УИХ-д үзүүлэх итгэлээс 5-9 оноогоор дээгүүр байна. Өмнөх онтой



харьцуулбал УИХ 1.2, Засгийн газар 6.4, Ерөнхийлөгч 11.4 оноогоор буурсан байгаа нь тэдэнд хүлээлгэж байгаа ард түмний итгэл суларсан байгаа нь харагдаж байна.

**2.3 Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаарх иргэдийн төсөөлөл (МХЗ-ын 67-р шалгуур үзүүлэлт)**

Судалгаанд оролцсон иргэдээс сүүлийн 12 сард төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагаас авсан үйлчилгээг асууж “тийм” гэж хариулсан иргэдээс үйлчилгээ авах үед авлига ажиглагдсан эсэхийг тодруулж асуусан юм.

Хүснэгт 2.6

**Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээнд авлига байгаа эсэх талаарх иргэдийн төсөөлөл**

Үйл ажиллагаа	Хариулт, хувь				Авлига ажигласан/ажиглаагүйн тооны харьцаа	
	Сүүлийн 12 сард үйлчилгээ авсан иргэдийн хувь		Үйлчилгээ авах үед авлигын асуудлыг анзаарсан иргэдийн хувь		2011	2012
	2011	2012	2011	2012		
Ажилд оруулах /өөрөө болон бусдыг, төрийн албанд/	14.78	13.50	5.87	4.80	0.40	0.36
Хүүхэд сургуульд оруулах	22.07	21.21	4.84	4.11	0.22	0.19
Курс болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах	10.66	10.16	2.20	1.60	0.21	0.16
Сургалтын дүн тавиулах	8.79	7.79	2.87	1.97	0.33	0.25
Тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудлуудыг шийдэх (Автын үзлэг, оношлогоо гэх мэт)	24.60	24.83	4.70	3.81	0.19	0.15
Эмнэлгийн үйлчилгээ авах	58.53	59.48	10.21	10.38	0.17	0.17
Баг, хорооны Засаг даргын тодорхойлолт авах	53.74	54.87	2.31	1.12	0.04	0.02
Цэргийн албанаас чөлөөлөгдөх	7.65	6.27	1.48	1.28	0.19	0.20
Нийгмийн халамж, тусламж, үйлчилгээ авах	48.82	41.21	2.76	2.69	0.06	0.07
Төсөл, зээл, тусламжид хамрагдах	12.69	12.99	2.39	3.01	0.19	0.23
Банкнаас зээл авах	28.39	33.10	2.37	2.08	0.08	0.06
Газрын зөвшөөрөл авах	13.92	14.54	3.42	4.43	0.25	0.30
Гаалийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх	2.62	2.24	0.95	0.75	0.36	0.33
Татвараас хөнгөлөх, чөлөөлөх/гаалийн татвараас бусад/	2.70	2.67	0.70	0.56	0.26	0.21
Шүүхээр хэрэг шийдвэрлүүлэх	3.26	3.65	1.48	1.55	0.45	0.42
Хилээр их хэмжээний бараа оруулах, гаргах	2.78	2.11	1.06	0.72	0.38	0.34
Паспорт авах /Дотоод, Гадаад/	15.70	22.73	1.95	1.31	0.12	0.06
Виз авах	4.43	4.64	1.00	0.77	0.23	0.17
Хэргийг аль нэг шатанд хэрэгсэхгүй болгох	2.25	2.03	1.09	0.75	0.48	0.37
Тусгай зөвшөөрөл лиценз авах	2.56	2.37	1.11	0.99	0.43	0.42
Төндөрийн шалгаруулалтад нөлөөлөх	2.09	1.52	0.89	0.77	0.43	0.51
Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ хийлгэх	6.60	6.59	1.25	1.23	0.19	0.19

Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээнд авлига байгаа эсэх талаарх иргэдийн төсөөллийг авч үзвэл, судалгаанд хамрагдагсдын 50-иас дээш хувь нь сүүлийн 12 сард баг, хорооны засаг даргын болон эмнэлгийн үйлчилгээнд, 41 хувь нь нийгмийн халамж, тусламж, үйлчилгээнд, 33 хувь нь банкнаас зээл авах үйлчилгээнд, 21-25 хувь нь хүүхэд сургуульд оруулах, паспорт авах болон тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудлыг шийдэх үйл ажиллагаанд, 10.2-14.5 хувь нь ажилд оруулах, төсөл,

зээл, тусламжид хамрагдах, газрын зөвшөөрөл авах үйл ажиллагаанд болон курс, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байна /Хүснэгт 2.6/.

Сүүлийн 12 сард төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн 10.4 хувь нь эмнэлгийн үйлчилгээ авахад, 3.0-4.8 хувь нь төсөл зээл тусламжид хамрагдах, тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудал шийдвэрлэх үйлчилгээ авах, ажилд орох, хүүхдээ сургуульд оруулах, банкнаас зээл авах үедээ авлига ажиглагдсан гэж хариулсан нь бусад чиглэлийн үйл ажиллагааныхаас илүү байна.